

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 23/17

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирал томилж, гэрээ байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 76.1.8, 76.1.9, Компанийн дүрмийн 8.12.9, 8.12.10, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.2.4, Гүйцэтгэх удирдлагын багийн үйл ажиллагааны дотоод журмын 2.1.2, 2.1.3-р зүйл, ТУЗ-ын 2023 оны 09-р сарын 11-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Бодь даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирлын ажлын байранд Ангиа овогтой Энхжаргалийг томилж, Онцгой нөхцөл бүхий Хөдөлмөрийн гэрээ байгуулсугай.
2. Компанийн санхүүгийн баримт бичигт 1-р гарын үсэг зурах эрх болон компанийг төлөөлөх, тушаал шийдвэр баталгаажуулах, хэлцэл хийх, гэрээ байгуулах зэрэг компанийн дүрэмд заасан Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг А.Энхжаргалд олгосугай.
3. Гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий Хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу түүний үүрэг хариуцлага, цалин хөлс болон бусад эрх хэмжээг тогтоосугай.
4. Гүйцэтгэх захирлын ажлыг түр орлон гүйцэтгэгч Б.Хүдэртулга нь Шинээр томилогдож байгаа Гүйцэтгэх захирал А.Энхжаргалд ажлыг хүлээлцэж өгөхийг үүрэг болгосугай.
5. Шинээр томилогдсон Гүйцэтгэх захиралд Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Гүйцэтгэх удирдлагын багийн үйл ажиллагааны дотоод журам түүнтэй холбоотой дүрэм журмыг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.
6. Тогтоолын биелэлтийг хангуулж ажиллахыг Дотоод аудитор Ш.Бэжид-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ